



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 513

Улаанбаатар хот

Тогтоол хүчингүй болсонд  
тооцох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны хуралдааны 28 дугаар тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврыг тус тус үндэслэн Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор ТОГТООХ нь:

1.Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 1-1/3492 дугаар албан бичгийн дагуу дагаж мөрдөх шаардлагагүй болсон, хууль тогтоомжтой зөрчилдсөн хавсралтад заасан Төрийн өмчийн хорооны тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хууль зүйн хэлтэс (Б.Гаваа)-т даалгасугай.

ДАРГА Ц.НЯМ-ОСОР  
ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн  
513.. дугаар тогтоолын хавсралт

**ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ  
ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ ТОГТООЛ**

Д/д	Баталсан байгууллага	Тогтоолын		Тогтоолын утга	Бүртгэгдсэн	
		Огноо	Дугаар		Огноо	Дугаар
1.	Төрийн өмчийн хороо	1997.01.03	2	Хөдөлмөрийн хөлс, урамшууллын тухай	1997.12.19	1103
2.	Төрийн өмчийн хороо	1997.09.12	462	Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт оруулан хувьчлах ажлыг зохион байгуулах журам	1997.12.19	1101
3.	Төрийн өмчийн хороо	1998.01.09	14	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	1998.03.30	1165
4.	Төрийн өмчийн хороо	1996.11.08	31	Төрийн өөрийн өмчийн барилга байгууламж болон үндсэн хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэх төсөл шалгаруулах журам	1998.04.06	1176
5.	Төрийн өмчийн хороо	1998.10.02	667	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1998.10.23	1291
6.	Төрийн өмчийн хороо	1999.03.04	128	Журамд өөрчлөлт оруулах тухай	1999.06.21	1429
7.	Төрийн өмчийн хороо	1998.08.28	563	“Төрийн өмчийн аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт оруулан хувьчлах тухай журам”-д өөрчлөлт оруулах тухай	2003.06.11	2079
8.	Төрийн өмчийн хороо	2001.03.22	123	“Аймаг, нийслэлийн нийтийн аж ахуй, үйлчилгээний зарим байгууллагыг менежментийн гэрээгээр ажиллуулах журам”, “Аймаг, нийслэлийн нийтийн аж ахуй, үйлчилгээний байгууллагыг менежментийн гэрээгээр ажиллуулах гэрээний улгэрчилсэн	2003.05.26	2042

				загвар"		
9.	Төрийн өмчийн хороо	2009.01.21	12	Түрээсийн гэрээний заалтад нэмэлт оруулах тухай	2009.10.13	3081
10.	Төрийн өмчийн хороо	2010.07.22	342	Уралдаант шалгаруулалтын жишиг баримт бичиг, журам батлах тухай	2011.05.16	3244